

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

[Марч легал эдвайс ХХК]

УЛААНБААТАР ХОТ
2025 он

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

- 2.1. “Зорилгод хүрэх байдал”;
- 2.2. “Ойлгомжтой байдал”;
- 2.3. “Харилцан уялдаа”.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

- 3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт;
- 3.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт;
- 3.3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт.

ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

- 4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн үнэлгээ;
- 4.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн үнэлгээ;
- 4.3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 17, 18 дугаар зүйлд заасны дагуу Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн төслийн бичвэрийг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж өгөх зорилгоор хийж гүйцэтгэв.

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн /цаашид “Хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын² 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-г баримтлан доорх үе шаттайгаар хийв. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Үр нөлөөний үнэлгээ хийсэн хуулийн төслийн хувилбарыг энэхүү тайланд хавсаргав.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

2.1. Шалгуур үзүүлэлт сонгосон үндэслэл:

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д заасан 6 шалгуур үзүүлэлтээс хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, гарах үр дагаврыг урьдчилан тогтоож чадахуйц дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонгосон болно. Үүнд:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл болон түүний зорилго нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан зорилгын хүрээнд боловсруулагдаж чадсан эсэх болон бодит үндэслэл, шаардлагад нийцэж буй байдал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь төслийн зорилгыг хангахад чиглэсэн бөгөөд түүнд хүргэх боломжтой эсэхийг

¹ Эрх зүйн цахим мэдээллийн сан;

² Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт.

үнэлнэ.

Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөлтэй танилцаж хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг судлан үзсэний дагуу хуулийн төслөөс түүний зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн бөгөөд хуулийн зорилгыг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ буюу зохицуулалтыг сонгож авав.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэх, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах зорилгоор хуулийн төслийг бүхэлд нь үнэлэхээр сонголоо. Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь үнэлэх бөгөөд хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль холбогдох бусад хуультай болон хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо нийцсэн эсэх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчилдөөнгүй эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр сонгов.

2.2. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал, практикт хэрэгжих боломж болон зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй тухайд:

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр тухайн хуулийн төслийн зохицуулалтыг иргэн, хуулийн этгээд хэрхэн хүлээн авах, тэдгээрт шинээр үүрэг хүлээлгэсэн эсэхийг шалгадаг. Тус хуулийн төслөөр иргэн, хуулийн этгээдэд шинээр ямар нэгэн чиг үүргийг шинээр нэмж хүлээлгэхгүй тул уг шалгуураар үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

“Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зардлын тооцоог Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тусад нь хийх тул энэхүү шалгуур үзүүлэлтийн үнэлгээг уг тайлангаас тусдаа бие даасан үнэлгээгээр тооцох юм.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэх, хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, санхүү болон хүний нөөцийн байдал зэргийг тогтоодог. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Гамшгаас хамгаалах тухай хууль 2017 оны 02 сарын 02-ны өдөр батлагдан хэрэгжиж эхэлсэн ба хуулийн төслийг бусад 4 шалгуураар үнэлэх боломжтой гэж үзсэн болно.

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

*Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн
төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан*

Хүснэгт1.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 1 болон 2 дугаар зүйлийг хамруулах	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2.	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30, 32 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
3.	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.1, 29.1.2, 29.1.3, 29.1.5, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг шалгах.

3.1. Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгахын тулд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, эдгээр зохицуулалт нь үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг харьцуулан дүгнэхээр зарчмын шинжтэй өөрчлөлтийг үнэлэхээр дараах байдлаар үнэлэх хэсгээ тогтоолоо.

Хүснэгт2.

Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлага	Хуулийн төслийн зохицуулалт
1/Гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг иргэдэд тэгш, хүртээмжтэй хүргэх, гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор онцгой байдлын байгууллагын салбар нэгжгүй суманд онцгой байдлын байгууллагын	<u>Хуулийн төслийн 1 дүгээр зүйл:</u> 5/ “12.5.Стратегийн болон улсын онц чухал объектод гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор гамшгаас хамгаалах хяналтын

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

мэргэжлийн алба хаагчийг ажиллуулах, томоохон аж ахуйн нэгжид гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны ажилтан, улсын онц чухал болон стратегийн зориулалттай төрийн өмчит үйлдвэрийн газарт гэрээт нэгж болон гэрээт байцаагчийг ажиллуулах асуудлыг тусгана.	улсын байцаагчийг гэрээгээр ажиллуулж болох бөгөөд холбогдох зардлыг тухайн байгууллага хариуцна.” 15/ “42.10.Онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй сумын Засаг даргын тамгын газарт онцгой байдлын байгууллагын нэг алба хаагчийг томилж ажиллуулна.” “42.10.1.сумын Засаг даргын тамгын газарт томилогдон ажиллаж байгаа алба хаагчийн зардлыг төр хариуцна.”
2/Гамшгаас хамгаалах олон нийт, иргэдийн сургалт, мэдээлэл, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, гамшгийн эрсдэлийн үнэлгээний тусгай зөвшөөрөл, түүний хэрэгжилт, хяналттай холбоотой чиг үүргийг хуулийн этгээд, тухайлбал төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гэрээгээр гүйцэтгүүлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.	Хуулийн төслийн 2 дугаар зүйл: 3/ “7.5.Онцгой байдлын байгууллага гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээнд хяналт тавих бөгөөд энэхүү чиг үүргийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хуулийн этгээдээр гэрээгээр гүйцэтгүүлж болно.” 6/ “13.9.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 13.3.2, 13.3.3, 13.3.4, 13.3.6, 13.3.7-д заасан гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа зохион байгуулах, мэдээллээр хангах чиг үүргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хуулийн этгээдээр гэрээгээр гүйцэтгүүлж болно.”
3/ Гамшгийн үед нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөлт, зохион байгуулалтын арга хэмжээ авах асуудлыг Засгийн газрын бүрэн эрхэд тусгаж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлтгэл, бэлэн байдал, хариуцлагын тогтолцоог оновчтой болгох шаардлагатай.	<u>Хуулийн төслийн 1 дүгээр зүйл:</u> 3/10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсэг: “10.7.Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт хэрэгжүүлэх нийтлэг арга хэмжээг тогтоох журмыг Засгийн газар батална 6/ “13.6. Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, аж ахуйн нэгжийн удирдлага, ажилтан, албан хаагч, иргэнд гамшгаас хамгаалах мэдлэг, дадлага олгох зорилгоор гамшгаас хамгаалах иж бүрэн болон гамшгаас

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

	хамгаалах команд штабын дадлага сургуулийг зохион байгуулна.” <u>Хуулийн төслийн 2 дугаар зүйл:</u>
4/ Онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдлыг хангахтай холбоотой зохицуулалтыг нэмж тусгах	<u>Хуулийн төслийн 1 дүгээр зүйл.</u> 10/ 29.1.20.гамшигтай тэмцэх техник, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын хувцас хэрэгсэл, хүнсний болон шатахууны нөөц бүрдүүлэх. 16/ 50 дугаар зүйлийн 50.15-50.18 дахь хэсэг 50.15.Онцгой байдлын байгууллагын захиалгаар гадаадын их, дээд сургуульд суралцагч офицер, ахлагчийн суралцах хугацааны цалин хөлс болон ирэх, буцах нэг удаагийн тээврийн зардлыг төр хариуцна. 50.16.Гадаадын их, дээд сургуульд суралцагчид цалин хөлс олгох журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 50.17.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. 50.18.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид олгох хүнсний болон эдийн хангалт, хоолны зардлын хэмжээг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга тогтооно.

3.2.“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:

Хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэх, Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах зорилгоор хуулийн төслийг бүхэлд нь үнэлэхээр сонголоо.

3.3.”Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:

Хуулийн төсөл нь өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой нийцэж буй эсэхийг “харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн тусламжтайгаар тогтоох юм. Уг шалгуур үзүүлэлтээр хуулийн төслийн зохицуулалтыг үнэлэхдээ тодорхой стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах тул хуулийн төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт, зохицуулалтыг бус төслийг бүхэлд нь сонгон авч үнэлэх нь зүйтэй тул хуулийн төслийг бүхэлд нь үнэлэхээр сонгосон болно.

ДӨРӨВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ

Өмнөх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх хуулийн төслийн зохицуулалтыг тухайн шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийг ашиглан хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх юм. Шалгуур үзүүлэлтийг дараах шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх болно.

Хүснэгт3

д/д	Шалгуур үзүүлэлт	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх: Хуулийн төслийн зохицуулалт нь төслийн үзэл баримтлалд дурдсан хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийнэ.
2	Ойлгомжтой байдал	Ойлгомжтой байдлыг шалгах: Хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хууль, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэхийг шалгана.
3	Харилцан уялдаа	Харилцан уялдааг шалгах: Хуулийн төслийн уялдаа холбоог аргачлалын 4.10-т заасан асуултад хариулах замаар шалгана.

Дээрх урьдчилан сонгож авсан шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төсөлд үр нөлөөний үнэлгээг дараах байдлаар хийв.

4.1."Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгахын тулд хуулийн төслийн үзэл баримтлалд³ тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, эдгээр зохицуулалт нь үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэхийг харьцуулан дүн шинжилгээ хийлээ.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" -ийн 4.4.4.14 дэх дэд заалтад "Гамшгийн шуурхай удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгож, гамшгийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, нийгэм, эдийн засагт учирч болзошгүй хүндрэлийг шийдвэрлэх эрх зүйн орчныг сайжруулна" гэж, Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 1.3 дахь хэсгийн 20-д Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тусгажээ.

Иймд дээрх бодлогын баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэх, хууль тогтоомжийн зөрчлийг арилгах зорилгоор Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон байх бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасан, түүнчлэн хуулийн төсөлд бүрэн дүүрэн, хангалттай тусгаж чадсан эсэхэд дараах байдлаар үнэлэлт, дүгнэлт хийлээ. Үүнд:

1.Гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг иргэдэд тэгш, хүртээмжтэй хүргэх, гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор онцгой байдлын байгууллагын салбар нэгжгүй суманд онцгой байдлын байгууллагын мэргэжлийн алба хаагчийг ажиллуулах, томоохон аж ахуйн нэгжид гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны ажилтан, улсын онц чухал болон стратегийн зориулалттай төрийн өмчит үйлдвэрийн газарт гэрээт нэгж болон гэрээт байцаагчийг ажиллуулах асуудлыг тусгах

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр Монгол Улсын нутаг дэвсгэрт тохиолдох үер, ган, зуд, салхи шуурга, хэт халалт, ой, хээрийн түймэр зэрэг байгалын аюулт үзэгдлийн давтамж нэмэгдэхээс гадна урьдчилан тааварлашгүй аюул учирч, олон улсын хөл хориот хүн, малын гоц халдварт өвчний шинэ тохиолдлууд гарч, олон хүний амь нас эрсдэж, мал, амьтан ихээр хорогдож, эд хөрөнгө сүйрч, улс орны нийгэм, эдийн засагт их хэмжээний хохирол учирч байгаа талаар хуулийн төслийн үзэл баримтлалд тодорхой судалгаатайгаар дурдсан байна.

Мөн уг нөхцөл байдлыг олон нийтийн оролцоонд тулгуурлаж гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх,

³ Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал

*Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн
төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан*

салбар дундын харилцан ажиллагаа, удирдлага, зохицуулалт, зохион байгуулалтыг сайжруулах хэрэгцээ шаардлага байгаа талаар дурджээ.

Иймд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэг “Стратегийн болон улсын онц чухал объектод гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор гамшгаас хамгаалах хяналтын улсын байцаагчийг гэрээгээр ажиллуулж болох бөгөөд холбогдох зардлыг тухайн байгууллага хариуцна” гэж, мөн 42 дугаар зүйлийн 42.10 дахь хэсэг “Онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй сумын Засаг даргын тамгын газарт онцгой байдлын байгууллагын нэг алба хаагчийг томилж ажиллуулна.” гэж тус тус нэмэхээр тусгасан нь оновчтой гэж үзэн дэмжиж, ийнхүү үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлага хуулийн төсөлд бүрэн тусгалаа олсон байна гэж дүгнэж байна.

Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэгт “стратегийн болон улсын онц чухал объект” гэсэн нэр томъёоны хувьд Дотоодын цэргийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “улсын онц чухал объект” гэж Монгол Улсын Засгийн газраас тогтоосон онцгой ач холбогдол бүхий байгууллага, үйлдвэр, барилга байгууламжийг ойлгоно гэж заасан. Харин “стратегийн объект” гэж ямар объект болох талаар бусад хуульд тодорхойлолт байхгүй буюу томъёоллын хувьд ойлгомжгүй байгааг анхаарах шаардлагатай байна.

2.Гамшгаас хамгаалах олон нийт, иргэдийн сургалт, мэдээлэл, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, гамшгийн эрсдэлийн үнэлгээний тусгай зөвшөөрөл, түүний хэрэгжилт, хяналттай холбоотой чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гэрээгээр гүйцэтгүүлэх нөхцөлийг бүрдүүлэх

Гамшгаас хамгаалах тухай хуульд зааснаар гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгосон байгууллага тухайн эрсдэлийн үнэлгээний тайлан, гүйцэтгэлд хяналт тавьж байгаа нь ил тод байдал, хариуцлагын хүрээнд сөрөг үр дагавар бий болгож болзошгүй юм. Түүнчлэн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх зардал харилцан адилгүй байхын зэрэгцээ тухайн үнэлгээг хийлгэхэд хуулийн этгээдээс гарах зардлын хэмжээ хэт өндөр байгаагийн улмаас хуулийн этгээд нь эрсдэлийн үнэлгээ хийлгэх бус Зөрчлийн тухай хуульд заасны дагуу торгууль төлөх сонголт хийхэд хүргэж, улмаар гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, хийлгэхтэй холбогдох зохицуулалт хэрэгжих боломжгүй, үр нөлөөгүй байдалд орж байгаа талаар Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайнанд дурджээ. Иймд “Онцгой байдлын байгууллага гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээнд хяналт тавих бөгөөд энэхүү чиг үүргийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хуулийн этгээдээр гэрээгээр гүйцэтгүүлж болно” гэж оруулсан нь дээр дурдсан хэрэгцээ шаардлагад нийцэж байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогод төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлнэ гэж заасан.

*Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн
төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан*

Үзэл баримтлалд гамшгаас хамгаалах олон нийт, иргэдийн сургалт, мэдээлэл, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, гамшгийн эрсдэлийн үнэлгээний тусгай зөвшөөрөл, түүний хэрэгжилт, хяналттай холбоотой чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гэрээгээр гүйцэтгүүлэх хэрэгцээ шаардлага байгаа талаар тусгасан ба хуулийн төсөлд 7.5 дахь хэсэг, 13.9 дэх хэсгийг тус тус нэмэхээр тусгасан нь үзэл баримтлалд дурдсан энэхүү хэрэгцээ, шаардлагад нийцэж байна гэж үзэхээр байна.

Харин хуулийн төсөлд 7.5 болон 13.9 дэх хэсгийг нэмэхдээ “.... холбогдох хууль тогтоомжийн дагуу хуулийн этгээдээр гэрээгээр гүйцэтгүүлж болно.” гэж тусгасан байх бөгөөд хуулийн этгээд гэж ерөнхий томьёолсон нь хуулийн төслийн үзэл баримтлалд томьёолсноос хальсан гэж үзэхээр байна.

Өөрөөр хэлбэл, Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно” гэж заасан байх бөгөөд мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газрын бус” гэдгийн “олон нийтийн байгууллага” гэж томьёолсноос үзэхэд төрийн зарим чиг үүргийг хуулийн этгээдийн бүх хэлбэрээр гүйцэтгүүлэх боломжгүй байна.

Иймд хуулийн төслийн үзэл баримтлалд төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлнэ гэж заасантай яв цав нийцэхгүй байгаа тул дээрх 2 хэсгийн хуулийн этгээдээр гэснийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлнэ гэж хуулийн төслийн үзэл баримтлалтай нийцүүлэх нь зүйтэй байна.

3.Гамшгийн үед нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөлт, зохион байгуулалтын арга хэмжээ авах асуудлыг Засгийн газрын бүрэн эрхэд тусгаж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлтгэл, бэлэн байдал, хариуцлагын тогтолцоог оновчтой болгох

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд ”Гамшгийн менежментийн тогтолцоог бэхжүүлж эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж, төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлж, чадавхийг бэхжүүлнэ” гэж заасан.

Хуулийн төслийн үзэл баримтлалд дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр Монгол Улсын нутаг дэвсгэрт тохиолдох үер, ган, зуд, салхи шуурга, хэт халалт, ой, хээрийн түймэр зэрэг байгалын аюулт үзэгдлийн давтамж нэмэгдэхээс гадна урьдчилан тааварлашгүй аюул учирч, олон улсын хөл хориот хүн, малын гоц халдварт өвчний шинэ тохиолдлууд гарч, олон хүний амь нас эрсдэж, мал, амьтан ихээр хорогдож, эд хөрөнгө сүйрч, улс орны нийгэм, эдийн засагт их хэмжээний хохирол учирч байгаа талаар дурджээ.

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

Гамшгийн эрсдэлийг бууруулах гол хүчин зүйлүүдийн нэг нь гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах асуудал бөгөөд гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт хэрэгжүүлэх нийтлэг арга хэмжээг тогтоох нь чухал тул хуулийн төсөлд 10.7 дахь хэсэг “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт хэрэгжүүлэх нийтлэг арга хэмжээг тогтоох журмыг Засгийн газар батална” гэж нэмэхээр оруулсан нь үзэл баримтлалд дурдсан хэрэгцээ шаардлагад нийцэж байна гэж үзэхээр байна.

Мөн Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланд дараах асуудлыг хөндсөн байна. Үүнд:

1. Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах байгууллага, албан тушаалтныг сургалтын ангиллаас хамаарахгүй тусгасан нь сургалтыг ангилах зорилт, ач холбогдлыг бууруулж байна. Нэг гишүүнтэй хуулийн этгээд зэрэг сургалт хүлээн авагч байгууллагын онцлогийг харгалзах байдлаар зохицуулалтыг уян хатан байдлаар боловсронгуй болгох шаардлагатай.

2. Гамшгаас хамгаалах сургалттай холбоотойгоор окутан, сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдэд зориулсан сургалтын зохицуулалт хэвээр байгаа ч зохион байгуулах байгууллага, албан тушаалтантай холбоотой зохицуулалтыг хүчингүй болгосноор хууль хоорондын уялдаа холбоо алдагдаж, тухайн зохицуулалт практикт хэрэгжихгүй байх шалтгаан болжээ.

Дээрх нөхцөл байдал нь гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулахтай холбоотой зохицуулалт зорилгодоо бүрэн хүрч чадахгүй байна гэж үзэхээр байна. Сургалтын арга хэмжээ нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд онцгой ач холбогдолтой учир холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангах хувилбарыг тусгах, сургалт явуулах хүний нөөц, сургалтын хүртээмж, чанарыг сайжруулах зэрэг асуудлыг цогцоор нь авч үзэх хэрэгцээ, шаардлагын дагуу хуулийн төсөлд 13.6 дахь хэсэг болох “Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, аж ахуйн нэгжийн удирдлага, ажилтан, албан хаагч, иргэнд гамшгаас хамгаалах мэдлэг, дадлага олгох зорилгоор гамшгаас хамгаалах иж бүрэн болон гамшгаас хамгаалах команд штабын дадлага сургуулийг зохион байгуулна.” гэж, мөн дээр дурдсанчлан сургалт зохион байгуулах, мэдээллээр хангах асуудлыг төрийн байгууллага дангаараа хэрэгжүүлэх биш хувийн хэвшлийг татан оролцуулах хувилбарыг нэмэхээр тусгасан нь хуулийн төслийн үзэл баримтлалд нийцсэн гэж үзэхээр байна.

4/ Онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдлыг хангахтай холбоотой зохицуулалтыг тусгах

Хуулийн төслийн үзэл баримтлалд онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдал, эрх, үүрэг, нийгмийн баталгаа, удирдах албан тушаалтны бүрэн эрх, үүрэг, хариуцлагын талаарх зохицуулалтыг оновчтой болгох, хэрэгжилтийг хангах механизмыг цогцоор нь бүрдүүлэх, хийдэл, зөрчлийг залруулах

замаар тус байгууллагын мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх зарчим, эрх зүйн зохицуулалтыг бэхжүүлэх шаардлагатай гэжээ.

Хуулийн төсөлд 29.1.20 дахь заалт болон 50.15-50.18 дахь хэсэг нэмж онцгой байдлын алба, түүний алба хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгааг нэмэлтээр оруулж байгаа нь үзэл баримтлалд дурдсан хэрэгцээ, шаардлагад нийцсэн гэж үзэж болохоор байна.

Иймд сонгон авсан хуулийн төсөлд тусгасан зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан зорилт, хэрэгцээ, шаардлагад зарчмын хувьд нийцсэн гэж дүгнэж болохоор байна.

4.2. “Ойлгомжтой байдлыг шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төсөл нь “Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэхийг шалгасан байдал:

Хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг аргачлалын дагуу дараах асуултад хариулт өгөх байдлаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцсэн эсэх:

Хүснэгт4

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх;	-Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 11-т 32.2.1 дахь заалтыг нэмэхдээ “нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ иргэд, олон нийт, нөхөрлөл, сайн дурынхан, сууц өмчлөгчдийн холбоог татан оролцуулж хамтарч ажиллах, урамшуулал авах” гэж тусгажээ. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд багийн Засаг дарга хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө урамшуулал авах хуулийн зохицуулалт байхгүй бөгөөд тухайн урамшууллыг ямар хууль тогтоомжид заасны дагуу ямар журмаар олгох, хэн олгох, урамшууллын хэмжээ нь ямар байх талаар тусгагдаагүй бусад хуультай уялдаагүй байх тул 32.2.1 дэх заалтын “урамшуулал авах” гэснийг хасах. -Төслийн 1 дүгээр зүйлийн 12-т “34.1.4.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх” гэж тусгажээ. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9-д “Албан татвар төлөгчийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй доор дурдсан үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжих зорилгоор элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг энэ хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татвараас хасаж хөнгөлнө.” гэж, 22.9.5-д “давагдашгүй хүчин зүйл болон түүнтэй адилтгах бусад гамшгийн улмаас хохирол барагдуулах” гэж тус тус заасан. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 12-т 34.1.4 дэх заалтыг нэмж байгаа нь дээрх ААНОАТтХ-тай уялдсан байна.
--	---

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан байна.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	-Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр нэмж буй 13.10-т “Гамшгаас хамгаалах талаар олон нийтэд ойлголт, мэдлэг олгоход чиглэсэн мэдээлэл, сургалт, нэвтрүүлгийг Олон нийтийн радио, телевизээр улирал тутам, тогтоосон цагт нийтийн хүртээл болгоно.” гэж заасан байна. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн бодлого, тусгай шаардлагыг хуульчилсан бөгөөд гамшгаас хамгаалах талаар олон нийтэд чиглэсэн мэдээлэл бэлтгэх үүргийг хуульчлаагүй байх тул холбогдох заалтыг салбарын хуульд тусгасны үндсэн дээр хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр 13.10 дахь заалтыг нэмэх нь зүйтэй байна. Өөрөөр хэлбэл, Гамшгаас хамгаалах тухай хуульд Олон нийтийн радио, телевизэд үүрэгжүүлсэн заалт оруулсан нь тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан гэж үзэхээр байна.

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан байна.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	- Хуулийн 8.1-д “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна.” гэж заасан. Мөн Гамшгаас хамгаалах тухай хуулиар хуулийн этгээд, төрийн бус байгууллагын эрх, үүргийг тусад нь зохицуулсан байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр 8.5 дахь хэсгийг нэмж, гамшгаас хамгаалах төлөвлөгөөгүй байж болох аж ахуйн нэгжийн 3 нөхцөлийг шинээр нэмсэн байна. Гэтэл Хуулийн төслийн 2 дугаар зүйлд 35.1 дэх хэсгийг өөрчлөн найруулахдаа хуулийн этгээдийн эрх, үүргээс эшлэн төрийн бус байгууллагыг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байхаар оруулсан нь хуулийн 8.1 дэх хэсэгтэй зөрчилдөж байна. Өөрөөр хэлбэл, хуулийн 8.1 дэх хэсэгт заасан этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байхаар заасан ба төрийн бус байгууллагыг гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байхаар зохицуулаагүй байна.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Хуулийн төсөлд ийм зохицуулалт тусгагдаагүй байна.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Төслийн 1 дүгээр зүйлийн 9-д 26.1.10 дахь заалтад хийсэн “энэ хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасан ...” гэж эшлэл буруу хэрэглэснийг засаж “Энэ хуулийн 25.1-д ..” гэж өөрчлөх.

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх;	Хуулийн төсөлд үүнтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй байна.
29.2. Хуулийн төсөлд шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох, зарим үг, өгүүлбэр, тоо, тэмдэгт хасах талаар тусгана.	Хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалт тусгагдаагүй байна.
29.3.Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна.	Хуулийн төсөлтэй холбогдуулан Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын хэвлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан байна.
29.4.Энэ хуулийн 14.5-д зааснаас бусад хуулийн төслийг дагалдуулан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэхийг хориглоно.	Хуулийн төслийг дагалдуулан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг боловсруулаагүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх;	-Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 16-д өөрчлөн найруулахаар тусгасан Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34.2.8 дахь заалтыг “гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед өөрийн өмчлөлийн болон эзэмшлийн газар, барилга байгууламж, эд хөрөнгө, техник хэрэгсэл, бараа материалыг холбогдох байгууллагын шийдвэрийн дагуу ашиглуулах;” гэж өөрчлөн найруулахаар тусгажээ. Иргэний хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-т “Аливаа этгээдийн эзэмшилд байгаа эд юмсыг эд хөрөнгө гэнэ.” гэж, 84.2-т “Эд хөрөнгө нь үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө байна.” гэж тус тус заасан. Хуулийн төсөлд тусгаснаар техник хэрэгсэл, бараа материал нь эд хөрөнгө гэсэн ойлголтод багтах бөгөөд “бараа материал” гэсэн нэр томьёо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд байхгүй байх тул Иргэний хууль болон бусад хуульд нийцүүлэн уг агуулгыг найруулгын хувьд оновчтой тодорхойлох буюу “гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед өөрийн өмчлөлийн болон эзэмшлийн газар, барилга байгууламж болон бусад эд хөрөнгийг холбогдох байгууллагын шийдвэрийн дагуу ашиглуулах;” гэж найруулах. -Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 5-д “12.5.Стратегийн болон улсын онц чухал объектод гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор гамшгаас хамгаалах хяналтын улсын байцаагчийг гэрээгээр ажиллуулж болох бөгөөд холбогдох зардлыг тухайн байгууллага хариуцна.” гэж тусгажээ. Мөн хуулийн төслийн 3 дугаар зүйлд 17.1.2 дахь заалтад стратегийн ач холбогдол бүхий гэж нэмэхээр тусгасан байх бөгөөд стратегийн ач холбогдол бүхий объект гэж юуг хэлж байгаа нь тодорхойгүй байна. Иймд стратегийн ач холбогдол бүхий объект эсхүл стратегийн объект
--	--

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

	гэсэн нэр томьёо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд байхгүй байх тул Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлэн уг агуулгыг найруулгын хувьд оновчтой тодорхойлох; -Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд нэмсэн 13.6, 13.7, 13.8 дахь хэсэгт “...команд штабын дадлага сургуулийг...” гэж тусгажээ. Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад хууль тогтоомжид команд штабын дадлага сургууль гэсэн нэр томьёо байхгүй бөгөөд шинэлэг ойлголт байх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.7-д “Нэр томьёо нь тодорхой утга агуулгаар зөвхөн нэг бүлэг, зүйл, хэсэг, заалтын хүрээнд хэрэглэгдэх бол түүний тодорхойлолт, тайлбарыг холбогдох бүлэг, зүйл, хэсэг, заалтын дотор байрлуулж болно.” гэж заасны дагуу тайлбарлан оруулах. -Төслийн 1 дүгээр зүйлийн 11-д “32.2.1.нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ иргэд, олон нийт, нөхөрлөл, сайн дурынхан, сууц өмчлөгчдийн холбоог татан оролцуулж хамтарч ажиллах, урамшуулал авах” гэж тусгажээ. Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад хууль тогтоомжид олон нийт, сайн дурынхан гэсэн нэр томьёо байхгүй бөгөөд Гамшгаас хамгаалах тухай хуульд сайн дурын хэсэг гэсэн нэр томьёог хуульчилсан тул сайн дурынхан гэснийг сайн дурын хэсэг гэж засах, олон нийт гэсэн нэр томьёо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд байхгүй байх тул Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлэн уг агуулгыг найруулгын хувьд оновчтой тодорхойлох;
30.1.2.нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Хуулийн төсөлд ийм зохицуулалт байхгүй байна.

30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	-Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 6-д 13.9 дэх хэсэгт “...холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гэрээгээр гүйцэтгүүлж болно.”, 2 дугаар зүйлийн 3-т 7.5 дахь хэсэгт “...холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээгээр гүйцэтгүүлж болно.” гэж заасан тул хууль шинээр боловсруулах, анхдагч хуулийн төсөл боловсруулах гэж өөр өөр тодорхойлсон нэр томъёог жигдлэн хуульд нийцүүлэн нэг мөр томъёолох. Мөн холбогдох хууль тогтоомж гэж ямар хууль тогтоомжийг тодорхойлж байгааг тодорхой оруулах эсхүл “холбогдох хууль тогтоомжийн хүрээнд” гэснийг хасч “гэрээгээр гүйцэтгүүлж болно” гэж найруулах. Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 11-т “23.1.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд Засгийн газар бодлого, стратегиар хангаж, онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн чиглүүлж, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга удирдан зохицуулж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагад тэдгээрийн удирдлага зохион байгуулж, хэрэгжүүлнэ.” гэж тусгажээ. Бодлого, стратеги гэх үг нь хоршоо үг биш байх бөгөөд стратегиар хангах гэсэн үгийн утга ойлгомжгүй байна. Түүнчлэн онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн чиглүүлж, онцгой байдлын байгууллагын дарга удирдан зохицуулж зэрэг шат шатны эрх бүхий этгээдүүдийн бүрэн эрх, чиг үүргийг нэг хэсэгт оруулан томъёолсон нь хууль тогтоомжийн төслийг ойлгоход хялбараар бичих гэсэн шаардлагад нийцэхээргүй гэж үзэж байна. Иймд дээрх хэсгийг тус тусын бүрэн эрх, чиг үүрэгт нь оруулах эсхүл энэ хэсгийн агуулга, үгийн сонголтыг
---	--

*Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн
төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан*

	ойлгомжтой болгон найруулах нь зүйтэй байна.
30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Хуулийн төсөлд ийм нэр томьёо тусгагдаагүй байна.

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Хуулийн төсөлд ийм зохицуулалт байхгүй байна.
--	---

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд нийцсэн эсэх:

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан шаардлагыг хуулийн төсөл хангасан эсэхийг нягтлах замаар шалгав.

- Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 11-т 32.2.1 дахь заалтыг нэмэхдээ 32.2-т өөрчлөн найруулга хийгээгүй байна. Өөрөөр хэлбэл заалтгүй хэсэгт заалт нэмэхдээ хэсэгт найруулга хийх шаардлагатай бөгөөд “Баг, хорооны Засаг дарга энэ хуулийн 32.1-д заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах эрх үүргээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гэж өөрчлөн найруулах.

- Төслийн 1 дүгээр зүйлд 4.1.27 дахь заалт бүхий “гамшигтай тэмцэх чадавх” гэсэн нэр томъёог тайлбарлан нэмсэн байх бөгөөд дугаарлалтыг нэр томъёоны тодорхойлолтын буюу 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн хамгийн сүүлийн заалт байхаар дугаарласан байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.3.3 болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын 4.1.4.1-т “... “Нийтлэг үндэслэл” бүлэгт “Хуулийн нэр томъёоны тодорхойлолт” гэсэн гарчигтай зүйлд нэр томъёоны цагаан толгойн үсгийн дарааллаар байрлуулна” гэж заасантай нийцүүлэн дугаарлах. Хуулийн төслийн 5 дугаар зүйлд нэр томъёоны тодорхойлолтуудын дугаарлалтыг өөрчилж байгаа байдлаар оруулах.

Хуулийн төслийн 1, 3 дугаар зүйлд стратегийн объект, стратегийн ач холбогдол бүхий объект гэж ижил агуулгыг өөр өөр нэр томъёогоор тодорхойлсон нь Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын 4.1.1.2-д “нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг, нэг ойлголтыг өөр өөр нэр томъёогоор илэрхийлэхгүй байх” гэснийг зөрчиж байна.

4.3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах асуултад хариулах замаар хуулийн төслийг бүхэлд нь үнэлж, хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах байдлаар уялдаа холбоог тогтоохыг зорьлоо.

1.Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх.

Хуулийн төсөл нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлага, зорилтод зарчмын хувьд нийцсэн байна гэж үзлээ.

2.Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх.

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан

Хуулийн төслөөр холбогдох хууль тогтоомж гэж ерөнхий байдлаар томьёолсон байх бөгөөд хуулийн төсөлд нийт 3 удаа холбогдох “хууль тогтоомжийн дагуу”, “холбогдох хууль тогтоомжийн хүрээнд” гэж хуулийн төсөлд оруулсан байна. Тухайлбал, хуулийн 37.1.3-т “гамшигт өртсөн тохиолдолд шаардлагатай тусламж, дэмжлэг авах” гэсэн заалтыг хуулийн төслөөр “37.1.3.гамшигт нэрвэгдсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагатай тусламж, дэмжлэг авах;” гэж өөрчлөн найруулсан байна. Гамшигт нэрвэгдсэн тохиолдолд Гамшгаас хамгаалах тухай хууль болон Засгийн газрын 2019 оны Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг хуулийн этгээдэд нөхөн олгох, нэрвэгдэгсдэд дэмжлэг үзүүлэх журамд заасны дагуу тусламж, дэмжлэг үзүүлэхээр зохицуулсан байна. Гамшигт нэрвэгдэгсдэд тусламж, дэмжлэг үзүүлэх хууль тогтоомж нь тодорхой байх тул хуулийн төсөлд “холбогдох хууль тогтоомж” гэснийг тодорхой болгох нь зүйтэй байна. Мөн хуулийн төсөлд 13.9 дэх хэсгийг нэмэхдээ “Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь ... чиг үүргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хуулийн этгээдээр гэрээгээр гүйцэтгүүлж болно” гэж, 7.5 дахь хэсгийг нэмэхдээ “7.5.Онцгой байдлын байгууллага ... чиг үүргийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хуулийн этгээдээр гэрээгээр гүйцэтгүүлж болно.” гэж тус тус тусгажээ. Энэ нь ямар хууль тогтоомжийн хүрээнд хуулийн этгээдээр гэрээгээр гүйцэтгүүлэх нь тодорхойгүй байх тул “холбогдох хууль тогтоомжийн хүрээнд/дагуу” гэснийг хасах нь зүйтэй байна.

3.Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх.

- Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд 4.1.27 дахь заалт бүхий “гамшигтай тэмцэх чадавх” гэж гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, аж ахуйн нэгж, иргэдийн хүч хэрэгслээ ашиглан эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах чадавхыг” гэх нэр томьёог нэмэхээр тусгасан байна. Харин хуулийн төслийн 2 дугаар зүйлд хуулийн 4.1.24 дэх заалтыг “бэлэн байдал” гэж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг шуурхай зохион байгуулах чадавхыг” гэж өөрчлөн найруулахаар боловсруулжээ. Дээрх 2 нэр томьёог харьцуулан үзвэл гамшигтай тэмцэх чадавх нь эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах чадавхийг ойлгохоор боловсруулсан бол бэлэн байдал нь хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг шуурхай зохион байгуулах чадавхийг ойлгохоор тусгажээ. Уг 2 нэр томьёог тайлбарласан байдал нь ижил буюу тайлбарласан байдлаас уг 2 нэр томьёо нь ижил агуулгатай мэт ойлгогдож байна.

- Түүнчлэн Хуулийн төслөөр “**8.4.Уул, уурхайн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдийн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг Онцгой байдлын байгууллага баталж, хяналт тавина.**” гэж шинээр нэмэхээр тусгажээ. Гэтэл Гамшгаас хамгаалах тухай хуульд гамшгаас хамгаалах төлөвлөгөөний талаар зохицуулсан бөгөөд хуульд аюулын үед хэрэгжүүлэх

төлөвлөгөөний талаар зохицуулалт байхгүй байна. Иймд аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө, гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь ялгаатай эсэх, хэрэв ялгаатай бол тайлбарлах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, Хуулийн төслийн 8 дугаар зүйл нь бүхэлдээ гамшгаас хамгаалах төлөвлөгөөний талаар зохицуулсан байх бөгөөд 8.4 дэх хэсэгт аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө хэмээн ялгаатай нэр томъёогоор томъёолох нь ойлгомжгүй бөгөөд уялдаа холбоогүй байна.

4.Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8.1-д “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна.” гэж заасан. Үүнээс үзэхэд хуулийн этгээдийн бүх л хэлбэр гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байхаар тусгасан байна. Гэтэл Гамшгаас хамгаалах тухай хууль нь хуулийн этгээд, төрийн бус байгууллагын статусыг ялган хуульчилсан байх бөгөөд хуулийн этгээдийн эрх, үүргийг хуулийн 34 дүгээр зүйлд харин төрийн бус байгууллагын эрх, үүргийг хуулийн 35 дугаар зүйлд тус тус ялгамжтайгаар зохицуулжээ. Үүнээс харахад төрийн бус байгууллага нь Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан хуулийн этгээд гэх ойлголтод багтаж байгаа эсэх хэрэв багтаагүй тусдаа эрх, үүрэгтэй байхаар хуульчилсан тохиолдолд төрийн бус байгууллага нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөгүй байхаар хуульчлагдсан байна. Мөн хуулийн төслийн 8.5 дахь хэсгийг нэмэхдээ зөвхөн 3 нөхцөлийн аль нэгт тохирох аж ахуйн нэгжийг гамшгаас хамгаалах төлөвлөгөөгүй байхаар тусгасан байна. Үүнтэй адилаар төрийн бус байгууллагыг гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байх эсэхийг тодорхой зохицуулахаар тусгах нь зүйтэй байна.

Иймд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8.1 болон 34, 35 дугаар зүйлүүдийн уялдаа холбоог хангах шаардлагатай байна.

- Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр 8.4 дэх хэсэг нэмэхдээ “уул уурхайн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, ...” гэж тусгасан нь Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.21-д “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэж энэ хуулийн дагуу ашигт малтмал эрэх, хайх, ашиглах эрх авсан, эсхүл түүнийг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу шилжүүлэн авсан хуулийн этгээдийг;” гэж, 4.1.23-т “бичил уурхай эрхлэх” гэж үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 481.1-т заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-т заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагааг;” гэж, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 4.1.12-т “түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэж энэ хуулийн дагуу ашигт малтмал хайх, ашиглах эрх авсан хуулийн этгээдийг;” гэж тус тус заасантай нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл, дээрх хуульд зааснаар уул уурхайн үйлдвэрлэлийг хуулийн этгээд, эсхүл Иргэний хуулийн 481.1-д заасан бүртгэгдээгүй нөхөрлөл эрхлэхээр заасан байх тул хуулийн төслөөр оруулж буй 8.4 дэх хэсгийн “иргэн,” гэснийг хасах нь зүйтэй байна.

5.Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд дараах заалтыг нэмсэн ба “13.3.6.сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын байгууллагад суралцагчийн сургалтыг тухайн шатны боловсролын сургалтын байгууллага;” энэхүү заалт нь Боловсролын ерөнхий хуулийн 14.4-т “Бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт дараах агуулгыг заавал тусгаж, боловсролын сургалтын байгууллага өмчийн хэлбэр харгалзахгүй хэрэгжүүлнэ.” гэж, 14.4.7-д “... гамшгаас хамгаалах, аюулгүй амьдрах арга ухаан” гэж зохицуулсан нь агуулгын хувьд давхардаж байна гэж үзэхээр байна.

- Мөн хуулийн төслөөр 26.1.10 дахь заалт нэмэхдээ “энэ хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасан шийдвэр гарсан тохиолдолд гамшгийн нөлөөллийг бууруулах, хэвийн нөхцөлд оруулах зорилгоор жилийн батлагдсан төсвийн нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр **төсөв хооронд**, төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх” гэх 26.1.10 дахь заалт нэмжээ. Төсвийн тухай хуулийн 10.1.14-т буюу Засгийн газрын бүрэн эрхэд тухайн жилийн төсвийн хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалтад шинэ арга хэмжээ нэмж тусгахгүйгээр, тэдгээрийн гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийхээр заасан. Гэтэл хуулийн төсөлд “... төсөв хооронд, ... зохицуулалт хийх” гэж тусгасан нь Төсвийн тухай хуулийн 10.1.14-т заасантай нийцэхгүй байна. Түүнчлэн хуулийн төслөөр нэмж буй 26.1.10 дахь заалтын бусад агуулга нь Төсвийн тухай хуулийн 10.1.14-тэй давхардаж байна.

-Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 5-д “12.4.Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандарт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах болон аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд гамшгаас хамгаалах хяналтын улсын байцаагч хяналт тавина.” гэсэн хэсэг нэмсэн байна. Гэтэл Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7.5-д “Онцгой байдлын байгууллага гамшгийн эрсдэлийн үнэлгээний гүйцэтгэл, тайланд хяналт тавьж ажиллана.” гэж заасан ба хуулийн төсөлд “гамшгийн эрсдэлийн үнэлгээ, .. төлөвлөгөөний хэрэгжилтэд” гэж тусгаснаар одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7.5-д заасан Онцгой байдлын байгууллагын чиг үүрэгтэй давхардаж байгаа тул хуулийн төслөөр нэмж буй 12.4 дэх хэсгийн “гамшгийн эрсдэлийн үнэлгээ” гэснийг хасах.

6.Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх.

Шаардлага хангасан байна.

7.Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх.

- Хуулийн төслөөр хуулийн этгээд тэр дундаа уул уурхайн үйлдвэрлэл эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийг аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байх, тухайн төлөвлөгөөг Онцгой байдлын байгууллага баталж, хяналт тавихаар зохицуулжээ. Гэтэл Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34, 37 дугаар зүйлд хуулийн этгээд, иргэний эрх, үүргийг зохицуулсан ба хуулийн төслөөр 8.4 дэх хэсэг шинээр нэмэхээр тусгасантай холбогдуулан 34.2 дахь хэсэгт “хуульд заасан бусад” гэж нэмэх шаардлагатай гэж үзэж байна.

- Гамшгаас хамгаалах тухай хуульд зааснаар Засгийн газар “гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг батлах”, Улсын онцгой комисс “гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг батлах”, Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн “гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журам, заавар, салбар хоорондын харилцан ажиллагааны төлөвлөгөө, удирдамжийг батлах”, Онцгой байдлын ерөнхий газрын дарга “гамшгаас хамгаалах үйл ажиллагаа болон онцгой байдлын байгууллагад дагаж мөрдөх дүрэм, журам, заавар, стандартыг баталж мөрдүүлэх” бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэхээр хуулиар зохицуулсан байна. Дээрх хэм хэмжээний акт батлах эрх хэмжээ нь давхардсан байх тул ялгамжтай байдлаар буюу Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөх журмыг Засгийн газар, байгууллагын хэмжээнд мөрдөх журмыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга гэх мэтээр хэм хэмжээний акт батлах эрх хэмжээг ялган зохицуулах нь зүйтэй байна.

8.Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх.

Шаардлага хангасан байна.

9.Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх.

Хуулийн төсөлд 13.9 дэх хэсгийг нэмэхдээ “Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь ... чиг үүргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хуулийн этгээдээр гэрээгээр гүйцэтгүүлж болно” гэж, 7.5 дах хэсгийг нэмэхдээ “7.5.Онцгой байдлын байгууллага ... чиг үүргийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хуулийн этгээдээр гэрээгээр гүйцэтгүүлж болно.” гэж тус тус тусгасан байх бөгөөд тус чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой байна.

10.Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх.

Хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалт тусгагдаагүй.

11.Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх.

Хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалт тусгагдаагүй.

12.Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх.

Хуулийн төсөл нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй байна.

13.Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх.

Хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалт тусгагдаагүй.

14.Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх.

Хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалт тусгагдаагүй.

15.Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.

Хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалт тусгагдаагүй.

Иймд хуулийн төсөл нь энэхүү “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээний 2,3,4,5-д зааснаас бусад шалгуурын хүрээнд харилцан уялдаатай бичигдсэн байна гэж үнэлсэн бөгөөд эдгээр хэсэгт хийсэн үнэлгээг хуулийн төслийг боловсронгуй болгохдоо анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” зэрэг бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор боловсруулсан байх бөгөөд хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлага, зорилтыг зарчмын хувьд хангасан байна гэж үзлээ.

Харин хуулийн төслийн харилцан уялдааг хангах, Хууль тогтоомжийн тухай хууль болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд бүрэн нийцүүлэх үүднээс дараах зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна. Үүнд:

*Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн
төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан*

- Гамшгаас хамгаалах тухай хуульд зааснаар Засгийн газар, Улсын онцгой комисс, Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Онцгой байдлын ерөнхий газрын дарга гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх дүрэм, журам, зааврыг батлах бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэхээр хуульчилсан байна. Дээрх бүрэн эрх нь давхардсан гэж үзэхээр байх тул ялгамжтай байдлаар буюу Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөх журмыг Засгийн газар, байгууллагын хэмжээнд мөрдөх журмыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга гэх мэтээр хэм хэмжээний акт батлах эрх хэмжээг ялган зохицуулах;

- Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр 8.4 дэх хэсэг нэмэхдээ “уул уурхайн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, ...” гэж тусгасан нь Ашигт малтмалын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд “ашигт малтмал эрэх хайх, ашиглах үйл ажиллагааг хуулийн этгээд явуулахаар” тус тус заасантай нийцэхгүй байх тул хуулийн төслөөр оруулж буй 8.4 дэх хэсгийн “иргэн,” гэснийг хасах;

- Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд дараах заалтыг нэмсэн ба “13.3.6.сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын байгууллагад суралцагчийн сургалтыг тухайн шатны боловсролын сургалтын байгууллага;” энэхүү заалт нь Боловсролын ерөнхий хуулийн 14.4-т заасантай агуулгын хувьд давхардаж байх тул хасах;

- Хуулийн төсөлд 26.1.10 дахь заалт нэмэхдээ “... төсөв хооронд, ... зохицуулалт хийх” гэж тусгасан нь Төсвийн тухай хуулийн 10.1.14-т заасантай нийцэхгүй байна. Түүнчлэн хуулийн төслөөр нэмж буй 26.1.10 дахь заалтын бусад агуулга нь Төсвийн тухай хуулийн 10.1.14-тэй давхардаж байх тул тус заалтыг хасах;

- Гамшгаас хамгаалах тухай хууль нь төрийн бус байгууллага болон хуулийн этгээдийн эрх үүргийг ялган зохицуулсан ба төрийн бус байгууллагыг гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байхаар хуульчлаагүй байх тул Хуулийн төслийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “34.2.8” гэснийг хасах нь зүйтэй байна. Мөн Хуулийн төслийн 2 дугаар зүйлээр 35.1 дэх хэсгийг өөрлөн найруулахаар тусгасан атлаа хуулийн төслийн 3 дугаар зүйлээр 35.1 дэх хэсэгт нэмэлт оруулж давхардуулсан байх тул бичилтийн алдааг засварлаж нэмэлт оруулсан хэсгийг хасах;

- Хуулийн төсөлд “гамшгийн эрсдэлийн үнэлгээ, .. төлөвлөгөөний хэрэгжилтэд” гэж тусгаснаар одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7.5-д заасан Онцгой байдлын байгууллагын чиг үүрэгтэй давхардаж байгаа тул хуулийн төслөөр нэмж буй 12.4 дэх хэсгийн “гамшгийн эрсдэлийн үнэлгээ” гэснийг хасах;

- Төслийн 1 дүгээр зүйлийн 9-д 26.1.10 дахь заалтад хийсэн “энэ хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасан ...” гэж эшлэл буруу хэрэглэснийг засаж “Энэ хуулийн 25.1-д ..” гэж өөрчлөх;

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ хууль болон бусад хуулийн уялдаа холбоог хангах зорилгоор хуулийн төслийн 1

дүгээр зүйлээр нэмсэн 32 дугаар зүйлийн 32.2.1 дэх заалтын “урамшуулал авах” гэснийг хасах;

- Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 16-д өөрчлөн найруулахаар тусгасан Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34.2.8 дахь заалтыг Иргэний хууль болон бусад хуульд нийцүүлэн “гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед өөрийн өмчлөлийн болон эзэмшлийн газар, барилга байгууламж болон бусад эд хөрөнгийг холбогдох байгууллагын шийдвэрийн дагуу ашиглуулах;” гэж найруулах;

- Хуулийн төсөлд тусгасан стратегийн ач холбогдол бүхий объект эсхүл стратегийн объект гэсэн нэр томьёо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд байхгүй байх тул Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлэн уг агуулгыг найруулгын хувьд оновчтой тодорхойлох;

- Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд нэмсэн 13.6, 13.7, 13.8 дахь хэсэгт “...команд штабын дадлага сургуулийг...” гэж тусгасныг Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.7-д “Нэр томьёо нь тодорхой утга агуулгаар зөвхөн нэг бүлэг, зүйл, хэсэг, заалтын хүрээнд хэрэглэгдэх бол түүний тодорхойлолт, тайлбарыг холбогдох бүлэг, зүйл, хэсэг, заалтын дотор байрлуулж болно.” гэж заасны дагуу тайлбарлан оруулах;

- Төслийн 1 дүгээр зүйлийн 11-д “32.2.1.нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ иргэд, олон нийт, нөхөрлөл, сайн дурынхан,...” гэж заасныг “иргэн, хуулийн этгээд, сайн дурын хэсэг” гэсэн хуульд байгаа нэр томьёоны дагуу боловсруулах;

- Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 6-д 13.9 дэх хэсэг нэмэхдээ “...холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гэрээгээр гүйцэтгүүлж болно.” гэж, 2 дугаар зүйлийн 3-т 7.5 дахь хэсгийг өөрчлөн найруулахдаа “...холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээгээр гүйцэтгүүлж болно.” гэж тус тус тусгасныг “гэрээгээр гүйцэтгүүлж болно” гэж найруулах;

- Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 11-т 32.2.1 дахь заалтыг нэмэхдээ 32.2-т өөрчлөн найруулга хийгээгүй байна. Өөрөөр хэлбэл заалтгүй хэсэгт заалт нэмэхдээ хэсэгт найруулга хийх шаардлагатай бөгөөд “Баг, хорооны Засаг дарга энэ хуулийн 32.1-д заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах эрх үүргээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гэж өөрчлөн найруулах;

- Төслийн 1 дүгээр зүйлд 4.1.27 дахь заалт бүхий “гамшигтай тэмцэх чадавх” гэсэн нэр томьёог тайлбарлан нэмсэн байх бөгөөд дугаарлалтыг нэр томьёоны тодорхойлолтын буюу 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн хамгийн сүүлийн заалт байхаар дугаарласан байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.3.3 болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын 4.1.4.1-т “... “Нийтлэг үндэслэл” бүлэгт “Хуулийн нэр томьёоны тодорхойлолт” гэсэн гарчигтай зүйлд нэр томьёоны цагаан толгойн үсгийн дарааллаар байрлуулна” гэж заасантай нийцүүлэн дугаарлах. Хуулийн төслийн 5 дугаар зүйлд нэр томьёоны тодорхойлолтуудын дугаарлалтыг өөрчилж байгаа байдлаар оруулах;

- Хуулийн төслөөр “8.4.Уул, уурхайн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдийн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг Онцгой байдлын байгууллага баталж, хяналт тавина.” гэж шинээр нэмэхээр тусгасан нь

*Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн
төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан*

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйл “Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх” гэсэн зүйлтэй уялдаагүй буюу гамшгаас хамгаалах төлөвлөгөө, аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө нь тусдаа өөр өөр ойлголт байх тул 8.4 дэх хэсгийг тусад нь зүйл болгон оруулах;

- Хуулийн төслөөр 37.1.3 дахь заалтыг гамшигт нэрвэгдсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагатай тусламж, дэмжлэг авах,” гэж тусгасан ба холбогдох хууль тогтоомжид гэснийг “энэ хуульд заасан журмын дагуу” гэж өөрчлөх.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ:

- Ø Хууль тогтоомжийн тухай хууль /2015 он/;
- Ø Гамшгаас хамгаалах тухай хууль /2017 он/;
- Ø Монгол Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;
- Ø Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан Шинэ сэргэлтийн бодлого;
- Ø Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”;
- Ø Төсвийн тухай хууль /2011 он/;
- Ø Иргэний хууль /2002 он/;
- Ø Боловсролын ерөнхий хууль /2023 он/;
- Ø Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /2020 он/
- Ø Олон нийтийн радио, телевизийн тухай хууль /2005 он/;
- Ø Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”;
- Ø Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”, 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”;

*Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн
төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан*

Ø Монгол Улсын Шадар сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтран баталсан Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үеэл баримтлал;

Ø Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс боловсруулсан Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын судалгааны тайлан /2025 он/